



ЗАХИРАЛБ.МЯГМАРАН

2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгууллагын нэр: И МОНГОЛ АКАДЕМИ УТУГ
Аудитын санал дүгнэлт: Хязгаарлалттай дүгнэлт

2023 оны 04 дүгээр сарын 10

Улаанбаатар хот

№	Зөрчлийн товч утга	Дүн мян.төг	Өгсөн зөвлөмж	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах албан тушаалтан	Хугацаа
1	2	3	4	5	6	7
1.ТӨЛБӨРИЙН АКТ-1						
1	Тайлант онд орон нутагт ажилласан албан томилолтын зардлаас 573.1 мянган төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсан	573.1	Дээрх зөрчлийг арилгаж нийт 573.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх.	Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу сонсох ажиллагааг хийж актын төлбөрийг төлж барагдуулах. <u>Санал:</u>	Ерөнхий нягтлан бодогч Г.Амгалан	05 дугаар сарын 15-ны дотор
2.АЛБАН ШААРДЛАГА-5						
2	Нэр бүхий 1 аж ахуйн нэгжтэй "Ажил гүйцэтгүүлэх гэрээ"-г байгуулан засварын ажлын зураг төслийг 19,800.0 мянган төгрөгөөр хийлгэсэн боловч засварын ажил хийгдээгүй, үргүй зардал гаргасан.	19,800.0	Төсвийн хөрөнгөөр гүйцэтгүүлсэн засварын ажлын зураг төслийг ашиглах, зөрчлийг давтан гаргахгүй байх.	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах; Засварын ажил хийх асуудлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар эцэслэн шийдвэрлүүлэх. <u>Санал:</u> Энэ жилийн төсөвт тусгагдсан Урсгал засварын зардлын төсвөөс хэтэрсэн тул батлуулсан зураг төслийн дагуу засвар хийх боломжгүй. Харин уг зардлыг 2024 оны төсвийн төсөлд	Ерөнхий нягтлан бодогч Г.Амгалан	Сар бүр

				тусгаж батлуулснаар энэхүү ажлын зургаар хийгдэх боломжтой.			
3	Эдийн засгийн зардлын ангилал зөрчиж дараах ажил гүйлгээг хийсэн байна. Үүнд: Зардлын ангилал 210801 ангиллаас 37,100.0 мянган төгрөгийн ширээ, сандлыг 18,000.0 мянган төгрөгийн хувцас, зөөлөн эдлэлийг, 210901 ангиллаас 1,029.6 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг худалдан авсан.		Холбогдох хууль, журамд заасныг зөрчлийг мөрдөх, зөрчлийг давтан гаргахгүй байх.	Харилцах дансны зарлагын журналыг дараа сарын 02-ны өдрийн дотор татаж зарлагын гүйлгээг зарлагын эдийн засгийн ангиллын дагуу хийсэн эсэхэд хяналт тавьж ажиллах. <u>Санал:</u>	Хяналт- шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн Э.Мөнхзул	Сар бүр	
4	Тайлант хугацаанд сандал, ширээ, тавилгыг худалдан авахдаа нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь багцалж тендер шалгаруулалт явуулаагүй байна. Тухайлбал: Тэн бий ХХК-тай 19,600.0 мянга, Ногоон Газар Бүтээмж ХХК-тай 19,800.0 мянга, Лока ХХК-тай 17,300.0 мянга, Баганат Биг Сервис ХХК-тай 17,300.0 мянга, нийт 74,000.0 мянган төгрөгийн тавилгыг шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн.		Үндсэн хөрөнгө худалдан авахдаа нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь багцалж тендер сонгон шалгаруулалт зохион байгуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.	Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах журмын дагуу худалдан авалтыг зохион байгуулж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах. <u>Санал:</u>	Ерөнхий нягтлан бодогч Г.Амгалан	Сар бүр	
5	Тайлант хугацаанд орон нутагт ажилласан албан томилолтоор ажиллахдаа 4 ширхэг суудлын автомашиныг өндөр үнэтэй түрээсэлж, нийт 23,400.0 мянган төгрөгийг түрээсийн төлбөрт зарцуулсан байна.		Түрээсийн автомашиныг зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаас түрээслэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.	Засгийн газрын автобааз ААТҮГ-аас автомашин түрээсийн үйлчилгээ авах, тус байгууллагаас үйлчилгээ авах боломжгүй нөхцөлд хот хоорондын зорчигч тээвэр, ачаа тээврийн үйлчилгээг ашиглаж байх. <u>Санал:</u> Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн 6.3 д заасны дагуу мөрдөн ажиллахаас гадна цаашид томилолтоор явахад овор багатай тоног төхөөрөмж авч явахаар бол нийтийн тээврийн хэрэгслээр зорчих, авто базаас машин гаргуулах боломжийг бүрдүүлэх төлөвлөгөө боловсруулах, зэргээр хэмнэж орон нутагт ажиллах болно.	Ерөнхий нягтлан бодогч Г.Амгалан	Тухай бүр	
6	Тус байгууллагын захирлын 2022 оны Б/01 дугаар тушаалаар баталсан "Албан тушаалын цалингийн шатлал, сүлжээ"-г мөрдөж байгаа нь холбогдох хууль тогтоомжид заасантай нийцэхгүй байна.		Засгийн газраас албан тогтоосон цалингийн итгэлцүүр, шатлалыг	Асуудлыг судалж боломжит хувилбаруудыг танилцуулж холбогдох арга хэмжээг авч ажиллах. <u>Санал:</u>	Хуулийн мэргэжилтэн О.Янжмаа	05 дугаар сарын 15-ны дотор	

		мөрдөх, зөрчлийг даван гаргахгүй байх.				
Албан шаардлагын дүн		19,800.0				
3.3ӨВЛӨМЖ-2						
7	Тус байгууллага нь бичиг хэрэг, шуудан холбоо, интернетийн төлбөр гэх мэт нийт 25,244.6 мянган төгрөгийн ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн байна.	25,244.6	Ажил гүйлгээг шууд зардалд бүртгэхгүй, тооцооны дансаар дамжуулан бүртгэж байх, алдааг даван гаргахгүй байх.	Харилцах дансны зарлагын журналыг дараа сарын 02-ны өдрийн дотор татаж зарлагын гүйлгээг тооцооны дансаар дамжуулан бүртгэсэн эсэхэд хяналт тавьж ажиллах. <u>Санал:</u>	Хяналт- шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн Э.Мөнхзул	Сар бүр
8	Мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвартай инженерүүдтэй "Хөдөлмөрийн гэрээ"-г байгуулан цахимаар ажиллуулж, сар бүр гүйцэтгэсэн ажлыг дүгнэж цалин олгосон боловч цахимаар ажиллуулах талаар нарийвчлан зохицуулсан журам байхгүй байна.	-	Цахимаар ажиллах цагийн бүртгэл, гүйцэтгэсэн ажлын үр дүн, бүтээмжийг тооцох, дотоод хяналтыг хэрэгжүүлэх асуудлыг нарийвчлан тодорхойлох, алдааг даван гаргахгүй байх.	Цахимаар ажиллуулах журам боловсруулж холбогдох байгууллагуудаас санал авч шийдвэр гаргуулах. <u>Санал:</u>	Хүний нөөцийн мэргэжилтэн Б.Мандахсоёл	05 дугаар сарын 15-ны дугаар
Зөвлөмжийн дүн		25,244.6				
НИЙТ ДҮН		45,617.7				